Тус сургууль нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг дагаж мөрддөг бөгөөд тус бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,452.7 мянган төгрөг буюу 1.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	12,545.2	12,545.2
Бараа материал	105,543.2	120,103.6	14,560.4
Үндсэн хөрөнгө	2,387,682.0	2,335,123.7	(52,558.3)
Нийт хөрөнгө	2,493,225.2	2,467,772.5	(25,452.7)
Өр төлбөр	19,580.7	11,093.9	(8,486.8)
Засгийн газрын хувь оролцоо	2,473,644.6	2,456,678.6	(16,965.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,493,225.2	2,467,772.5	(25,452.7)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 12,545.2 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэлийн 2,545.2 мянган төгрөгийн илүү төлөлт, Нийслэлийн боловсролын газраас нэмэлт санхүүжилтийн дансанд 10,000.0 мянган төгрөгийн индексийн урамшуулал олгосныг тайлант хугацаанд зарцуулаагүй тул Сангийн яамтай тооцоо нийлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Бараа материал дансны үлдэгдэл 120,103.6 мянган төгрөг болж 14,560.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 163,679.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 6,191.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг шилжүүлэн авч, 155,310.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,335,123.7 мянган төгрөг болж, 52,558.3 мянган төгрөгөөр буурсан бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
 - Төсвийн хөрөнгөөр 1,349.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, Япон Монголын ротари клубээс 63,092.1 мянган төгрөгийн брайл принтер үнэ төлбөргүй хүлээн авч, дээд шатны төсөв захирагчаас 102,305.4 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч бүртгэсэн;
 - ТӨБЗГ-ын 2025 оны 845 дугаар тогтоолоор 119,366.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 194,955.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 11,093.9 мянган төгрөг болж 8,486.8 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, хоолны өглөг 19,580.7 мянган төгрөгөөр буурсан;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,456,678.6 мянган төгрөг болж, 16,965.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Судалгааны үр дүн:

Тус сургуулийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2019-2024 онуудад худалдан авч, сургалтын зориулалтаар ашиглаж байгаа 2 нэр төрлийн 8 ширхэг

23,498.2 мянган төгрөгийн өртөгтэй брайл үсгийн программ хангамж байна. Тайлант онд программ хангамжийг хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 3,419,786.1 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас зардлыг цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 253,199.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 107,710.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 14.6 мянган төгрөг нийт 360,925.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 30,909.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 25,456.2 мянган төгрөг, нормативт зардлыг 15,052.2 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 14,300.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,540.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 158.1 мянган төгрөг нийт 74,116.2 мянган төгрөгөөр бууруулж, багаж, техник хэрэгслийн зардал 101,000.0 мянган төгрөг, тавилгын зардлыг 75,500.0 мянган төгрөгийг хасаж, нийт 3,515,795.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,492,612.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, урсгал үйл ажиллагаанд 3,321,072.9 мянган төгрөгийг зарцуулж, 171,539.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,321,072.9 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 175,023.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлын 5,304.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 11,492.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

						/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70802	Ерөнхий боловсрол	3,515,795.0	3,321,072.9	194,722.1	94.5	
1.1	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	70,187.9	70,090.5	97.4	99.9	
1.2	81801	Үдийн цай хөтөлбөр	69,484.6	69,484.6	-	100.0	
1.3	81806	Дотуур байрны үйлчилгээ	61,659.5	61,659.5	-	100.0	
1.4	81847	Тусгай хэрэгцээт боловсрол	3,314,463.0	3,119,838.2	194,624.8	94.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Тус сургуулийн дотоод журмын 7.11-ийн 14.15-д 1 хүнд ногдох хоолны хөнгөлөлтийг өдрийн 10.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 0.5 мянган төгрөг байхаар зохицуулж тайлант хугацаанд 190,367.2 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 15,085.0 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 12,056.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10,000.0 мянган төгрөг нийт 37,141.5 мянган төгрөгийн орлого орж, 17,553.5 мянган төгрөгийн урсгал засварт зарцуулан, зарцуулагдаагүй үлдэгдэл 19,588.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс 10,000.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тооцож бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн хоол, дотуур байрны хоолны худалдан авалтыг www.tender.gov.mn цахим дэлгүүрт байршсан Соргог бэлчээрийн мах ХХК-аас 28,592.0 мянган төгрөгийн мах, махан бүтээгдэхүүн, Сүү ХК-аас 2,890.0 мянган төгрөгийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдан авч, бусад хүнсний материалыг шууд худалдан авалтаар 5 аж ахуй нэгж байгууллагатай 36,177.5 мянган төгрөгийн худалдан авалт хийх гэрээ байгуулан, гэрээг дүгнэж, тооцоо нийлж, ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 26-наас 2026 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Т.Эх-Оюун, аудиторын туслах Э.Номинчулуун нар гүйцэтгэж, захирал Ч.Мөнхтуяа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,037,821.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 30,378.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус сургууль нь албан бичгийн төсөл, цагийн бүртгэл, чөлөөний хуудас зэргийг байгууллагын дотоод сүлжээ болон албаны цахим шууданг ашиглан захиргаанд илгээдэг байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу захиргаанаас нэгдсэн журмаар албан бичиг, тушаал, шийдвэрийг гаргаж ажилладаг, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэж, нөөцлөөгүй, бичиг хэргийн зардлыг 2,321.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,492.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 5 мэдээллийн хугацаа хоцроож байршуулсан. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 4 гүйлгээний 205,315.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж, мэдээлэл хоцроох зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн алдаа, зөрчилд асуудлын бүртгэл хөтөлж, 761,017.5 мянган төгрөгийн 4 залруулга, 553,470.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг үнэлж, хэрэгжээгүй зөвлөмжийг энэхүү аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 11,048.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 424,397.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	11,048.9	2.0	11,048.9	-	-	100.0
Албан шаардлага	1	-	1.0	-			100.0
Зөвлөмж	3	424,397.2	3.0	424,397.2			100.0
Нийт дүн	6	435,446.1	6.0	435,446.1	-	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,711,402.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Татаас санхүүжилтийн 10,000.0 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлсэн акт үйлдээгүй, мөн байгууллагын үндсэн болон нэмэлт дансны 3,529,753.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Говь таван элс ХХК-аас 2025 оны 10–11 дүгээр сард худалдан авсан бичиг хэргийн материалтай холбоотой 109.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 171,539.2 мянган төгрөгийн тохируулах бичилт хийгээгүй зэрэг нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт заасантай тус тус нийцэхгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 15,656.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 9,384.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,271.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 15,656.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 30,378.2 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Хоол зүйчийн бичсэн хүнсний материалын нэр төрөл, тоо хэмжээний шаардах хуудаснаас нярав, нягтлан бодогч нь 9,384.7 мянган төгрөгөөр илүү зарлагадсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын шаардах хуудаснаас илүү дүнгээр зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 716 ширхэг 613,936.7 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-т хүсэлт өгч, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч

гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Нэр бүхий 3 ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд 5,789.8 мянган төгрөгөөр дутуу, 2 ажилтныг 481.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4 "ажил, гүйлгээний мэдээ гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тайланг холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв бэлтгэн тайлагнаж байх.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг гаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
								Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Татаас санхүүжилтийн 10,000.0 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлсэн акт үйлдээгүй, мөн байгууллагын үндсэн болон нэмэлт дансны 3,529,753.6 мянган төгрөгийн орлого, зарлагыг гүйлгээг харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	3,539,753.6	-	-	1	3,539,753.57	1	3,539,753.6	-	-	-	-
2	Говь таван элс ХХК-тай 109.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	109.2	-	-	1	109.20	1	109.2	-	-	-	-
3	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 171,539.2 мянган төгрөгийн тохируулах бичилт хийгээгүй байна.	1	171,539.2	-	-	1	171,539.25	1	171,539.2	-	-	-	-
	Дүн	3	3,711,402.0	-	-	3	3,711,402.0	3	3,711,402.0	-	-	-	-

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	Хоол зүйчийн бичсэн хүнсний материалын нэр төрөл, тоо хэмжээний шаардах хуудаснаас нярав, нягтлан бодогч нь 9,384.7 мянган төгрөгөөр илүү зарлагадсан байна.	1	9,384.7	1	9,384.7	-	-	-	-	-	-	-	-	-
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 716 ширхэг 613,936.7 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-т хүсэлт өгч, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
3	Нэр бүхий 3 ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд 5,789.8 мянган төгрөгөөр дутуу, 2 ажилтныг 481.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	6,271.7	-	-	-	-	1	6,271.7	-	-	-	-	-
4	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
	Дүн	4	15,656.4	1	9,384.7	-	-	1	6,271.7	-	-	-	-	-

Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн системд 5 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 4 гүйлгээний 205,315.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй.	1	205,315.6	-	-	-	-	1	205,315.6
	Дүн	1	205,316.6	-	-	-	-	1	205,315.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 24/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/160/НА-СТА-ТЦУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоол зүйчийн бичсэн хүнсний материалын нэр төрөл, тоо хэмжээний шаардах хуудаснаас нярав, нягтлан бодогч нь 9,384,653.00 /есөн сая гурван зуун наян дөрвөн мянга зургаан зуун тавин гурван/ төгрөгөөр илүү зарлагадсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү зарцуулсан 9,384,653.00 /есөн сая гурван зуун наян дөрвөн мянга зургаан зуун тавин гурван/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургуулийн захирал /Э.Нүрээд/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Ч.МӨНХТУЯА